

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийн техникийн байдал, хэрэглээний стандартын үзүүлэлтийг хангуулах, автотээврийн хэрэгслээс хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшин техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа үзлэгийн төвүүд, тээврийн хэрэгсэл өмчлөгч иргэн, хуулийн этгээдэд хамаарах бөгөөд Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын албаны автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаа хамаарахгүй.

1.3. Техникийн хяналтын үзлэгийн суурин болон явуулын төвд тавигдах шаардлагыг стандартаар тогтооно.

1.4. Монгол Улсад суугаа гадаад улсын Элчин сайдын яамд, Олон улсын байгууллагын автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэгийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай урьдчилан тохиролцсоны үндсэн дээр зохион байгуулна.

Хоёр. Техникийн хяналтын үзлэгийг зохион байгуулах

2.1. Үзлэгийн төв нь техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагааг зохион байгуулахдаа дор дурдсан журам, стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллана. Үүнд:

- 2.1.1. "Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм;
- 2.1.2. "Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага" MNS 5011;
- 2.1.3. "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага" MNS 5012;
- 2.1.4. "Бензин хөдөлгүүртэй автомашин-Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга" MNS 5013;
- 2.1.5. "Дизель хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга" MNS 5014;
- 2.1.6. "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598;
- 2.1.7. "Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд" MNS 4599;

- 2.1.8. “Автотээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томъёо, тодорхойлолт” MNS ISO 3833;
- 2.1.9. “Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг. Ерөнхий шаардлага” 1-р хэсэг MNS 4410;
- 2.1.10. “Хүнд даацын автотээврийн хэрэгсэл. Тавигдах шаардлага”. MNS 6278;
- 2.1.11. “Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5122;
- 2.1.12. “Автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар.(VIN) -Агуулга ба бүтэц” MNS ISO 3779;
- 2.1.13. “Автотээврийн хэрэгслийн -Дэлхийн үйлдвэрлэгчийг таних тэмдэг.(WMI)-ийн код” MNS ISO 3780;
- 2.1.14. “Автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар. (VIN) байрлал ба бэхэлгээ” MNS ISO 4030;
- 2.1.15. “Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага” MNS 6440;
- 2.1.16. “Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага” MNS 4978;
- 2.1.17. “Жуулчны автотээврийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5231,.

2.2. Техникийн хяналтын үзлэгийг стандарт, хэмжил зүйн байгууллагаар баталгаажуулсан тоног төхөөрөмжөөр аймгийн төв, нийслэлд итгэмжлэгдсэн суурин төвд, аймгийн төв, нийслэлээс алслагдсан нутаг дэвсгэрт явуулын төвөөр гүйцэтгэнэ.

2.3. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын шаардлага хангасан техникийн хяналтын үзлэгийн суурин төвд энэхүү журмын нэгдүгээр хавсралтад дурдсан гэрчилгээг олгоно.

2.4. Нийтийн хэрэгцээний авто замд ашиглах боломжгүй өөрөө явагч машин, хүнд механизм, мотоцикл, троллейбуст техникийн хяналтын үзлэгийг явуулын төвөөр хийж гүйцэтгэнэ.

2.5. Өөрөө явагч машин, хүнд механизмын утааны найрлага дахь хорт бодисын хэмжээг үндэслэн техникийн хяналтын үзлэгийн системд бүртгэнэ.

2.6. Троллейбуснаас бусад нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглаж байгаа автотээврийн хэрэгслийг зөвхөн суурин төвд техникийн хяналтын үзлэгт хамруулна.

2.7. Явуулын төв нь битүү тэвштэй, техникийн хяналтын үзлэгийн зориулалтаар тоноглогдсон автотээврийн хэрэгсэл байна.

2.8. Авто замын засвар, барилга угсралтын ажлын үед зам, талбай хаагдах зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр үйл ажиллагаа тасалдах үед тусгай зөвшөөрөл олгогч төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гарган зөвшөөрсөн тохиолдолд тодорхой хугацаанд техникийн хяналтын үзлэгийг зөвхөн тухайн байршилд явуулын төвөөр зохион байгуулна.

2.9. Техникийн хяналтын үзлэгийн инженер нь автотээврийн хэрэгслийн марк, модель, улсын дугаар, арлын, бүхээгийн, хөдөлгүүрийн дугаар, өнгө, төрөл, зориулалт, өмчлөгчийн хаяг зэрэг бүртгэлийн үзүүлэлтийг автотээврийн хэрэгслийн гэрчилгээтэй нь нэг бүрчлэн тулгах бөгөөд автотээврийн хэрэгсэлд зайлшгүй шаардагдах нэмэлт хэрэгслийг холбогдох стандартын дагуу шалгана.

2.10. Автотээврийн хэрэгслийн өгөгдөл нь тухайн тээврийн хэрэгслийг тодорхойлсон баримт бичгийн өгөгдөлтэй нийцэж байвал уг тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулна.

2.11. Өгөгдөл нь зөрчилтэй болон арлын дугаарыг засварласан, арилгасан, үйлдвэрлэгчээс тогтоосон хийц, зориулалтыг үйлдвэрлэгчийн зөвшөөрөлгүй өөрчилсөн автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулахгүй.

2.12. “Автотээврийн хэрэгслийн үйлдвэрийн хийцийг өөрчлөн тоногловсон автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулахгүй бөгөөд зөвхөн үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн шаардлагыг хангуулсны дараа хамруулна.

2.13. Дараах тусгай тоноглол бүхий автотээврийн хэрэгслийг эрх бүхий мэргэжлийн байгууллагын шалгаж баталгаажуулсан дүгнэлтийг үндэслэн техникийн хяналтын үзлэгт хамруулна.

2.13.1. мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтэд автокраны, автотээврийн хэрэгсэлд суурилагдсан өргөх төхөөрөмжийн, аюултай ачаа тээвэрлэх торхны, хийгээр ажилладаг автомашины баллоны болон бусад даралтат савны баталгаажуулалт зэрэг хамаарна.

2.13.2. баталгаажуулалт нь гэрчилгээ, эсхүл дүгнэлт хэлбэртэй байх бөгөөд тодорхой хугацааг заасан байна.

2.14. Хийгээр ажилладаг автотээврийн хэрэгслийн хийн баллоны баталгаажилтын хугацаа дууссан эсэх болон хийн баллон, дамжуулах хоолой, хаалт, хавхлагийн битүүмжлэлийг шалгана.

Гурав. Техникийн хяналтын үзлэгийн төвийн эрх, үүрэг

3.1. Техникийн хяналтын үзлэгийн инженер нь хяналтын үзлэгт хамрагдсан автотээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч нарт тухайн автотээврийн хэрэгслийн техникийн байдлын талаар мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгааг өгнө.

3.2. Үзлэгт хамрагдсан боловч стандартын шаардлага хангаагүй, мөн үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгсэлд “тэнцсэн” тухай дүгнэлт гаргахгүй.

3.3. Техникийн хяналтын үзлэгт тэнцсэн автотээврийн хэрэгслийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийж, техникийн хяналтын үзлэгийн гэрчилгээ /цаашид “шошго” гэх/ олгоно.

3.4. Техникийн хяналтын үзлэгт тэнцсэн нийтийн зорчигч тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэрт тэмдэглэгээ хийнэ.

3.5. Техникийн хяналтын гэрчилгээ нь RFID (Radio Frequency IDentification) радио давтамжийн долгион ашиглан таних технологи дээр суурилсан цахим хэлбэртэй байна.

3.6. Радио давтамжийн долгион ашиглан таних технологи RFID (Radio Frequency IDentification) дээр суурилсан шошго нь энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасан загварт нийцсэн байна.

3.7. RFID (Radio Frequency IDentification) радио давтамжаар таних технологи дээр суурилсан шошгоны техникийн үзүүлэлт нь энэхүү журмын 3 дугаар хавсралтад

заасантай нийцэх бөгөөд технологийн технологийн дэвшлээс шалтгаалан өөрчлөлт оруулж болно.

3.8. Засгийн газрын шийдвэрээр батлагдсан техникийн хяналтын үзлэг явуулах хугацаа, төлбөрийн жишгийг үйл ажиллагаандаа баримтлана.

3.9. Техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаа эрхлэгч нь мэдээ, тайлангаа улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор цахим хэлбэрээр, жилийн эцэст тайлан хэлбэрээр автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.10. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автотээврийн хэрэгслийн мэдээллийг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон автотээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн цахим санд тухай бүрт нь оруулж, сүлжээгээр хүргүүлнэ.

3.11. Тухайн тээврийн хэрэгслийн баримт бичиг нь техникийн хяналтын үзлэгийн мэдээллийн сангийн мэдээлэлтэй зөрсөн, эсхүл засвартай байвал зөрчлийг арилгуулахаар тухайн асуудлыг шийдвэрлэх эрх бүхий байгууллага / хууль хяналтын, тээврийн хэрэгслийн бүртгэлийн, гаалийн болон бусад /-д шилжүүлэх, шаардлагатай тохиолдолд автотээврийн асуудал эрхэлсэн эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандан холбогдох зөвлөмж чиглэлийг авна.

3.12. Техникийн хяналтын үзлэгийн төв нь тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ашиглалт, баталгаажуулалтын бүртгэлийг хөтөлж, үзлэг явуулах дараалал, хугацааг агуулсан технологийн картыг батлуулан мөрдөхийн зэрэгцээ шаардлагатай бусад техникийн баримт бичгийг боловсруулж үйл ажиллагаандаа ашиглана.

3.13. Техникийн хяналтын үзлэг явуулах технологийн картыг ажлын байран дахь зураг авалтыг үндэслэн тогтоох бөгөөд архивлан хадгалж гарын авлага болгон ашиглана. 3.15. Техникийн хяналтын үзлэгийн төвийн байршил, цагийн хуваарь зэрэг үйлчлүүлэгчид хэрэгцээт мэдээллийг хэвлэл мэдээллийн болон бусад хэрэгслээр нийтэд мэдээлэх, техникийн хяналтын үзлэгт хамрагдах захиалгыг цахим сүлжээгээр хүлээн авах, техникийн хяналтын үзлэгийн дүгнэлтийг үйлчлүүлэгчид цахим хэлбэрээр хүргүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3.14. Техникийн хяналтын үзлэгийн чанар, бүртгэлийн мэдээллийн санд тээврийн хэрэгсэл бүрэн хамрагдсан эсэхэд автотээврийн хэрэгслийн бүртгэл хариуцсан байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн захиргааны байгууллага, тээврийн цагдаагийн алба хамтран хяналт тавина

3.15. Суурин болон явуулын төвөөр автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа хяналтын камер ашиглах бөгөөд бичлэгийг 1 жил 6 сараас доошгүй хугацаагаар архивлан хадгална.

Дөрөв. Автотээврийн хэрэгслийг өмчлөгч, эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эрх, үүрэг

4.1.Тээврийн хэрэгслийн өмчлөгч нь жолоочийн хариуцлагын даатгалд даатгуулсны дараа автотээврийн хэрэгслээ техникийн хяналтын үзлэгт хамруулна.

4.2. Иргэн, хуулийн этгээд нь тээврийн хэрэгслээ бүртгүүлсэн харьяаллаас үл хамааран техникийн хяналтын үзлэгийн аль ч төвд автотээврийн хэрэгслээ үзлэгт хамруулах эрхтэй.

4.3. Автотээврийн хэрэгсэл нь техникийн хяналтын үзлэгт анхны үзлэгээр тэнцээгүй тохиолдолд дахин хамрагдахдаа зөвхөн өмнө үзлэгт орсон төвдөө хандана.

4.2. Иргэн, хуулийн этгээд нь нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийг хагас жил тутам, бусад автотээврийн хэрэгслийг жилд нэг удаа тогтсон хугацаанд үзлэгт заавал хамруулна.

4.3. Тээврийн хэрэгслийг өмчлөгч, эзэмшигч иргэн, хуулийн этгээд нь техникийн хяналтын үзлэгт хамруулахын өмнө дараах бэлтгэл ажлуудыг хангасан байвал зохино.

4.3.1. баримт бичгийн бүрдлийг хангасан байх;

4.3.2. техникийн хяналтын үзлэгийн төлбөрийг төлсөн байх;

4.3.3. Цагдаагийн байгууллагаас бэлэн бус хэлбэрээр хуулиар оногдуулсан торгуулийг бүрэн төлж барагдуулсан байх;

4.3.4. тээврийн хэрэгслийн бохирдлыг арилгаж ерөнхий байдал иж бүрдлийн үзлэг хийх боломжийг бүрдүүлсэн байх;

4.3.5. Стандартаар тогтоосон жолоочид болон тээврийн хэрэгсэлд заавал байх шаардлагатай иж бүрдлийг хангасан байх.

4.3.6. Арлын дугаарыг ил болгон цэвэрлэж техникийн баримт бичигтэй тулган шалгах нөхцлийг бүрдүүлсэн байх.

4.4. Дараах тохиолдолд энэхүү журмын 4.1-т заасан хугацааг үл харгалзан тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулна. Үүнд:

4.4.1. хөдөлгүүр сольсон, өнгө өөрчилсөн, автотээврийн хэрэгслийн зориулалтыг үйлдвэрлэгчийн зөвшөөрлөөр өөрчилсөн, нэмэлт төхөөрөмж суурилуулсан бол;

4.4.2. автотээврийн хэрэгсэлд засвар, үйлчилгээ хийлгэсний дараа эзэмшигч нь хүсэлт гаргасан бол;

4.4.3. зам, тээврийн осолд өртөж хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх агрегат, зангилаа, механизмд эвдрэл, гэмтэл гарсан, түүнчлэн энэхүү заалтад дурдсан эвдрэл, гэмтэлтэй тээврийн хэрэгслийг засварласан бол дахин замын хөдөлгөөнд оролцохын өмнө;

4.4.4. автотээврийн хэрэгслийг Монгол Улсад үйлдвэрлэсэн, үйлдвэрлэгчийн технологийн шаардлагын дагуу угсарсан зэрэг хамаарна.

4.5. Олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх автотээврийн хэрэгсэлд Европын Холбооны 2014/45/ЕС удирдамжийн дагуу энэхүү журмын дөрөвдүгээр хавсралтад заасан мэдээллүүдийг агуулсан гэрчилгээг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгогдсон техникийн хяналтын үзлэгийн итгэмжлэгдсэн байгууллага олгоно.

Тав. Бусад

5.1. Автотээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигч нь технологийн картын дагуу үзлэг хийхийг шаардаж, чанаргүй үйлчилгээ үзүүлсэн гэж үзвэл гомдлоо тухайн

байгууллагын удирдлагад, шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрөл олгосон харьяалах дээд шатны байгууллагад хүсэлтээ гаргаж шийдвэрлүүлнэ.

5.2. Үйлчилгээтэй холбоотой гомдлыг иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

5.3. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

-----ooOoo-----

Зам, тээврийн хөгжлийн сайдын
20 ... оны ... сарын ... өдрийн ... дугаар
тушаалаар батлагдсан “Автотээврийн
хэрэгслийн техникийн хяналтын үзлэг
явуулах журам”-ын нэгдүгээр хавсралт

**АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ
АЖ АХУЙН НЭГЖИД ОЛГОХ ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР**

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ /нүүр /

Дугаар ...

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн ... дугаар зүйлийн.....
“Автотээврийн тухай” хуулийн ... заалтыг үндэслэн Зам, тээврийн хөгжлийн сайдын ...
оны ... дугаар тушаалаар ... улсын бүртгэлийн, ... регистрийн дугаартай

“ ” -д

(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

**АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ТЕХНИКИЙН
ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ХИЙХ АЖИЛ ЭРХЛЭХ**

тусгай зөвшөөрлийг ... оны ... дугаар сарын ... өдрөөс ... жилийн хугацаатай олгов

САЙД

/ар тал /

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр,	Үйл ажиллагааны төрөл	
	Суурин	Явуулын

2. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАСАН ТЭМДЭГЛЭЛ

д/д	Тусгай зөвшөөрлийг сунгасан тухай тэмдэглэл	Сунгалт хийсэн	
		Тушаалын дугаар, он, сар, өдөр	Гарын үсэг, тэмдэг

Энэхүү зөвшөөрөл нь гэрээний хамт хүчинтэй бөгөөд засвартай бол хүчингүй.

Зам, тээврийн хөгжлийн сайдын
20 ... оны ... сарын ... өдрийн ... дугаар
тушаалаар батлагдсан "Автотээврийн
хэрэгслийн техникийн хяналтын үзлэг
явуулах журам"-ын хоёрдугаар хавсралт

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

А. Гэрчилгээний нүүр тал


АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ


Б. Гэрчилгээний ар тал

№

Автоэврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар	
Автоэврийн хэрэгслийн арлын дугаар	
Марк, модель	
Үйлдвэрлэсэн он	
Өнгө	

В. Гэрчилгээний дотор байрлах микро схем



Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын
гэрчилгээнд түүнд тавигдах шаардлага

1. Гэрчилгээнд тавигдах ерөнхий шаардлага:

- 1.1. Радио долгионы давтамжийн RFID (Radio Frequency Identification) технологи дээр суурилсан байх бөгөөд уг шошго дотор дахин давтагдашгүй тэмдэгтүүдийг агуулсан микро схемтэй байна.
- 1.2. Тээврийн хэрэгслийг анх бүртгэхдээ RFID шошго болон QR (Quick Response) кодыг бүртгэлийн системд холбоно.
- 1.3. Монгол орны уур амьсгал, цаг агаарын нөхцөлд тохирсон, нарны гэрэлд гандахгүй, халуун, хүйтэн хуурахгүй байх ;
- 1.4. Бат бөх, өнгө будаг нь тод байх;
- 1.5. Төмөр, шил, мод, хуванцар зэрэг материал дээр наалдах чадвар сайтай, нэг удаа наасан тохиолдолд дахин ашиглах боломжгүй байх;
- 1.6. Тоос шороо, чийг нэвтрэхээс хамгаалагдсан байх;
- 1.7. Шошгоны урт 110 мм, өргөн нь 45 мм байна.

2. Гэрчилгээний нүүр тал

- 2.1. Гэрчилгээний нүүрэн талын суурь өнгө цэнхэр байх бөгөөд энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтын А хэсэгт заасантай нийцсэн, бичиглэл нь хар өнгөтэй байна.
- 2.2. QR код (Quick Response Code) нь 30мм х 30мм хэмжээтэй байна.
- 2.3. QR код нь ISO/IEC 18004:2015 стандартыг хангасан байх ба гэрчилгээнд тавигдах шаардлагын 1.1-т заасан RFID шошгоны дахин давтагдашгүй тэмдэгтүүдийн жагсаалтыг хөрвүүлэн гаргаж авна.

3. Гэрчилгээний ар тал

- 3.1. Гэрчилгээний ар талын суурь өнгө цагаан байх энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтын Б хэсэгт заасантай нийцсэн, бичиглэл нь хар өнгөтэй байна.

3.2. Техникийн үзүүлэлтүүд:

Өгөгдөл дамжуулах протокол	EPC global UHF Class 1 Gen 2 (ISO 18000-6C)
Давтамж	860~960 Mhz

Чипний төрөл	Alien Higgs-4
Санах ой	EPC 96- 480 bit, User 512 bit, TID 32 bit
EPC санах ойн мэдээлэл	Unique, randomized number
Уншуулж чадах зай	>3 метр
Тогтоох боломжтой материал	Шил, пластик, мод, төмөр
Материал	Хэвлэж болох
Антенны хэмжээ	44,5*10,38 мм
Жин	< 1 гр
Ажиллах боломжтой температур	-40° аас +70°С
Ашиглах хугацаа / хэвийн нөхцөлд/	10+ жил

Тайлбар: Хүснэгт 1-т заасан үзүүлэлтүүдийг “Зам, тээврийн хүрээлэн” НҮТББ-аас 2016 онд хийсэн “Тээврийн хэрэгсэлд бүртгэл хяналтын RFID суурилсан систем бүрдүүлэх, туршилт, судалгааны ажил” -ын эцсийн шатны тайланд үндэслэв.

4. Бусад

4.1. Гэрчилгээг тухайн автотээврийн хэрэгслийн урд салхины шилний дээд буланд жолоочийн харах орчныг хязгаарлахгүй, ил харагдахаар голлуулсан байдлаар байрлуулна.

4.2. Автотээврийн хэрэгсэл нь техникийн хяналтын үзлэгт тэнцсэн тохиолдолд гэрчилгээг бүртгэлийн системд бүртгэж мэдээллийг холбоно.

4.3. Гэрчилгээг ашиглах боломжгүй тохиолдолд дахин олгоно.

-----ooOoo-----

Зам, тээврийн хөгжлийн сайдын
20 ... оны ... дугаар сарын ... өдрийн ...
дугаар тушаалаар батлагдсан "Тээврийн
хэрэгслийн техникийн хяналтын үзлэг,
оношлогоо явуулах журам"-ын
дөрөвдүгээр хавсралт

Олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэлд олгох
техникийн хяналтын гэрчилгээнд зайлшгүй тусгагдах мэдээллүүд

Тээврийн хэрэгслийн арлын дугаар (VIN) Vehicle identification number (VIN number or chassis number)	
Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар Vehicle registration number	
Техникийн хяналт үзлэгт орсон он, сар, өдөр Date of vehicle technical inspection	
Техникийн хяналт үзлэгт орсон өдрийн одометрийн заалт Odometer readings on the day of vehicle technical inspection	
Тээврийн хэрэгслийн ангилал Vehicle category	
Илэрсэн алдаа, доголдол Faults and defects identified by vehicle technical inspection	
Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн дүн Vehicle technical inspection results	
Дараагийн техникийн хяналт үзлэгт орох хугацаа эсвэл олгосон гэрчилгээний дуусах хугацаа Date of next technical inspection or expiration date of issued certificate	
Техникийн хяналт үзлэгийн төв эсвэл байгууллагын нэр, хаяг, Техникийн хяналтын үзлэг хариуцсан ажилтны гарын үсэг Name of Vehicle Technical Inspection Organization or Inspection Station and address Signature of Inspector	
Бусад мэдээлэл Other information	

Тайлбар: Техникийн хяналтын олон улсын хорооны зөвлөмж болон Европын холбоо ба Европын холбооны парламентаас гаргасан 2014.04.03-ны өдрийн удирдамжаар техникийн хяналтын үзлэгийн гэрчилгээний агуулгыг тодорхойлсон байдаг.

---000---